


Тусдаа санхүүгийн тайлан ба Хараат бус аудиторын тайлан

Ард санхүүгийн нэгдэл ХК

2021 оны 12 дугаар сарын 31



Агуулга

Хараат бус аудиторын дүгнэлт	5
Тусдаа санхүүгийн байдлын тайлан	10
Тусдаа орлогын дэлгэрэнгүй тайлан	12
Тусдаа өмчийн өөрчлөлтийн тайлан	13
Тусдаа мөнгөн гүйлгээний тайлан	14
Санхүүгийн тайлангийн тодруулгууд	16

Компанийн талаарх мэдээлэл

Компанийн нэр:	Ард санхүүгийн нэгдэл ХК	
Үүсгэн байгуулах шийдвэр:	Ард санхүүгийн нэгдэл ХК нь 2007 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр анх үүсгэн байгуулагдсан.	
Төлөөлөн удирдах зөвлөл	Дарга	П.Батбаяр
	Гишүүд	Ч.Ганхуяг Бруно Рашле А.Сүхдорж О.Одбаяр
	Хараат бус гишүүн	М.Сэргэлэн Ч.Мөнхбат Михаил Зелдович Арнауд Вентура
Удирдлагын баг:	Гүйцэтгэх захирал	Ч.Ганхуяг
	Маркетинг эрхэлсэн захирал	Ц.Бархас
	Санхүү эрхэлсэн захирал	Б.Золбоо
	Хөрөнгө оруулалт эрхэлсэн захирал	Э.Амарбаясгалан
	Олон нийтийн харилцаа эрхэлсэн захирал	Ж.Алтангүний
	Технологи эрхэлсэн захирал	Э.Баярмагнай
	Дотоод аудитор	М.Мөнх-Эрдэнэ
	Хууль нийцүүлэлт эрхэлсэн захирал	С.Анар-Эрдэнэ
	Эрсдэл эрхэлсэн захирал	Б.Оюутцэцэн
Хаяг:	Ерөнхий нягтлан бодогч	Г.Сэлэнгэ
	Компани нь Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Централ Тауэр, 17 давхар	
	2001861	
Регистрийн дугаар:	2001861	
Үйл ажиллагаа:	Хөрөнгө оруулалт	
	Бизнесийн зөвлөгөө	
Ажиллагсадын тоо:	16	
Аудитор:	"Грант Торнтон Аудит" ХХК, Аудит, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн зөвлөгөө, сургалт, үнэлгээний итгэмжлэгдсэн байгууллага	


Удирдлагын мэдэгдэл

Удирдлага нь Ард санхүүгийн нэгдэл ХК-ийн тусдаа санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэж, Компанийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх санхүүгийн байдал, уг өдрөөр дуусвар болсон үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу зохистой толилуулах үүрэгтэй.

Тусдаа санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага дараах үүрэг хариуцлагыг биелүүлсэн. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн тохиромжтой бодлогыг сонгох, тууштайгаар даган мөрдөж, үндэслэлтэй, нягт нямбай тооцоолол, үнэлгээ хийж, бүх холбогдох нягтлан бодох бүртгэлийн стандартыг мөрдсөн.
- Компанийн эд хөрөнгийг хадгалан хамгаалах, аливаа заль мэх, зүй бус үйлдлээс сэргийлэх, ийм үйлдлийг илрүүлэхэд шаардлагатай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн.
- Тусдаа санхүүгийн тайланг тасралтгүй үйл ажиллагаанд үндэслэн бэлтгэсэн.
- Өнгөрсөн үйл явдлын үр дүнд хуулийн дагуу эсвэл үүсмэл үүрэг хариуцлага хүлээсэн, ирээдүйн үйл ажиллагаанд алдагдал хүлээж болзошгүй зүйлсийг байнга хянаж байх үүрэгтэй бөгөөд хуулийн дагуу эсвэл үүсмэл үүрэг хариуцлага, болзошгүй зүйлсийн талаар тодруулсан.

"Ард санхүүгийн нэгдэл" ХК-ийн ТУЗ-ийн дарга П.Батбаяр, Гүйцэтгэх захирал Ч.Ганхуяг болон Санхүү эрхэлсэн захирал Б.Золбоо бид энэхүү тайлангийн 10-50 дугаар хуудсанд үзүүлсэн компанийн санхүүгийн тайлангууд нь 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх компанийн санхүүгийн байдал, уг өдрөөр дуусгавар болсон жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн гэдгийг үүгээр мэдэгдэж байна.


П.Батбаяр
ТУЗ-ийн дарга


Ч.Ганхуяг
Гүйцэтгэх захирал



Огноо: 2022/03/31

Огноо: 2022/03/31


Б.Золбоо
Санхүү эрхэлсэн захирал

Огноо: 2022/03/31

“ГРАНТ ТОРНТОН АУДИТ” ХХК

Аудит, татвар, зөвлөх үйлчилгээний
дэлхийн сүлжээний бие даасан фирм

Далай тауэр, 9 давхар,
ЮНЕСКО гудамж - 31,
Сүхбаатар дүүрэг,
1 хороо Улаанбаатар
14230, Монгол улс
Т + 976 70 110744
+ 976 70 110799

Dalai Tower, 9 floor,
UNESCO street - 31,
Sukhbaatar District-1,
Ulaanbaatar 14230,
Mongolia
T + 976 70 110744
+ 976 70 110799

Хараат бус аудиторын дүгнэлт

Ард санхүүгийн нэгдэл ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд:**Дүгнэлт**

Бид Ард санхүүгийн нэгдэл ХК (цаашид “компани” гэх)-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-нээрх дараах санхүүгийн тайлангуудад (цаашид “тусдаа санхүүгийн тайлан” гэх)-д аудит хийлээ. Үүнд:

- Тусдаа санхүүгийн байдлын тайлан,
- Тусдаа орлогын дэлгэрэнгүй тайлан,
- Тусдаа өмчийн өөрчлөлтийн тайлан,
- Тусдаа мөнгөн гүйлгээний тайлан болон
- Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогын хураангуй,
- Бусад тайлбар тодруулгууд

Бидний дүгнэлтээр, Ард санхүүгийн нэгдэл ХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдал ба уг өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээ нь бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт (АОУС)-уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа *Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага* гэсэн хэсэгт харуулав.

Хараат бус байдал

Бид Нягтлан бодогчдын ёс зүйн Олон улсын стандартын зөвлөлийн мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Монгол улсын мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрмийн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн зохих шаардлагуудын дагуу тус Компаниас хараат бус бөгөөд эдгээр ёс зүйн шаардлагуудад нийцүүлэн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, зохистой гэж итгэж байна.

Аудитын аргачлалын хураангуй

Аудитын гол асуудлууд	• Виртуал хөрөнгөтэй холбоотой НББ-ийн бодлогод өөрчлөлт оруулсан. • Хаалттай охин компаниудад оруулсан хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийг үнэлж, бүртгэсэн.
Аудитын цар хүрээ	• Компани Тодруулга 15-д заасан охин компаниудыг эзэмшдэг боловч энэхүү тайлан нь тус компанийн тусдаа санхүүгийн тайлан болно.
Материаллаг байдал	• Санхүүгийн тайлангийн аудитад ашигласан нийт материаллаг байдал нь 1,300,000 мянган төгрөг ба материаллаг байдлыг сонгохдоо өмчийн 5%, нийт орлогын 3%-иар тооцож, дундаж утгыг авсан.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн үнэлэмжээр аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн тусдаа дүгнэлт гаргаагүй болно.

Аудитын гол асуудал	Аудитын гол асуудалд авсан хариу арга хэмжээ
<i>Виртуал хөрөнгийн НББ-ийн бодлогын өөрчлөлт</i> Тайлант онд компанийн виртуал хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлттэй холбоотой НББ-ийн бодлогод өөрчлөлт орсон. Тухайлбал виртуал хөрөнгийн бодит үнэ цэнийг сар бүр үнэлж, бодит үнэ цэнийн өөрчлөлт болон хойшлогдсон татварыг сар бүрийн эцэст санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрдөг байсан бол НББ-ийн бодлогодоо жилийн эцэст нэг удаа үнэлж, хүлээн зөвшөөрч байхаар болсон байна. Виртуал хөрөнгөтэй холбоотой НББ-ийн бодлогыг тодруулга 4.9-д, виртуал хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг тодруулга 19.4-д, виртуал хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлттэй холбоотой үүссэн хойшлогдсон татварын өглөгийг тодруулга 16-д тус тус харуулсан.	<i>Аудитын горим:</i> Бид НББ-ийн бодлогын өөрчлөлтөд тусгасан зааврын дагуу тайлант хугацаанд виртуал хөрөнгөтэй холбоотой гарсан ажил гүйлгээг дараах байдлаар шалгасан. Үүнд: - Виртуал хөрөнгийн хөдөлгөөнийг давтан шалгасан, - Виртуал хөрөнгийн өртгийг дундаж өртгийн аргаар тооцоолсныг давтан шалгасан, - Бодит үнэ цэнийн тооцооллыг шалгаж, биржийн хаалтын ханшаар хүлээн зөвшөөрсөн эсэхийг давтан шалгасан, - Үүссэн зарим зөрүүг санхүүгийн тайланд залруулсан болно.
<i>Хаалттай охин компаниудад оруулсан хөрөнгө оруулалтын бодит үнэ цэн</i> Ард санхүүгийн нэгдэл ХК нь тайлант хугацаанд хувьцааг нь 90-100 хувь эзэмшиж, бүрэн хянадаг охин компаниудад оруулсан хөрөнгө оруулалтыг СТОУС 13 <i>Бодит Үнэ Цэнийн Хэмжилт</i>-ийн дагуу үнэлж, санхүүгийн тайландаа бодит үнэ цэнээр нь хүлээн зөвшөөрсөн. Эдгээр компаниуд нь хаалттай компаниуд бөгөөд компанийн удирдлага эдгээр компаниудын бодит үнэ цэнийг үнэлэхдээ Үнэлгээний олон улсын стандартад заасан зах зээлийн хандлага, үүн дотроо нийтэд арилжаалагддаг жиших зүйлсийн аргыг ашигласан. Үнэлгээний үр дүнд хаалттай компаниудын бодит үнэ цэнэ нь материаллаг хэмжээгээр нэмэгдсэн ба үнэлгээнд их хэмжээний тооцоолол, мэргэжлийн шийдэл ашигласан тул аудитын гол асуудал гэж үзсэн.	<i>Аудитын горим:</i> Хаалттай охин компаниудад оруулсан хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийг үнэлж, санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрсөн асуудлыг аудитор хянахдаа дараах горимуудыг ашигласан. Үүнд: - Эдгээр хөрөнгө оруулалтыг үнэлэхдээ компанийн удирдлагын ашигласан тооцоолол, мэргэжлийн шийдэл үндэслэлтэй эсэх, тооцсон арга аргачлал, үнэлгээ бодитой эсэхийг хараат бус хөндлөнгийн мэргэжлийн үнэлгээчнээр шалгуулсан. - Үнэлгээ нь охин компаниудын цэвэр хөрөнгөд илүү төвлөрсөн учраас эздийн өмчид хамгийн материаллаг хэмжээгээр нөлөөлсөн орц, хүчин зүйлсүүд буюу оруулсан хөрөнгө оруулалтууд, арилжих зорилготой активууд, компаниудын эзэмшил дэх виртуал хөрөнгийн ханшийн хэлбэлзлийг зах зээлийн үнэ ханштай харьцуулан, дахин хянасан. Үнэлгээнд ашигласан арга хандлага, тооцоолол мэргэжлийн шийдлийг хэрхэн сонгосон талаар Компанийн удирдлагатай ярилцаж, шалтгааныг тодруулсан.

Онцлох асуудал

Ард санхүүгийн нэгдэл ХК нь групп компани бөгөөд тайлант онд 33 орчим охин болон хараат компанийг эзэмшдэг боловч тусдаа санхүүгийн тайланг бэлтгэж, хувьцаа эзэмшигчиддээ тайлагнадаг тул энэхүү шалтгааныг Тодруулга 2.1-д дэлгэрэнгүй тайлбарласан.

Ард санхүүгийн нэгдэл ХК нь дүрмэндээ хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа явуулна гэж заасан ба компанийн үйл ажиллагаа нь хөрөнгө оруулалтын аж ахуйн нэгжийн ихэнх шинжүүдийг хангаж байгаа боловч СТОУС 10 "Нэгтгэсэн санхүүгийн тайлан"-гийн 27, 31-д заасны дагуу хөрөнгө оруулалтын ААН-ийн санхүүгийн тайланг бэлтгэдэггүй.

2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу компанийн ТУЗ-ийн 2022 оны 2-р сарын 11-ний 22/02 тоот тогтоолоор компани нь Хөрөнгө оруулалтын аж ахуйн нэгжийн статусыг хүлээн зөвшөөрч, 2022 оны 1-р сарын 1-нээс компани дагаж мөрдөхийг үүрэг болгосон.

Энэ тогтоолын дагуу хөрөнгө оруулалтын аж ахуйн нэгжийн статусыг хүлээн зөвшөөрснөөр компани нь СТОУС 10 *Нэгтгэсэн санхүүгийн тайлан*-гийн 31-д заасны дагуу охин компаниудыг нэгтгэлээс чөлөөлж, эдгээр охин компаниудад оруулсан хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдлаар бүртгэх, 32-р заалтын дагуу зарим охин компаниудыг нэгтгэлд хамруулах нягтлан бодох бүртгэлийн бодлогоо тодорхойлж, хэрэгжүүлж ажиллах юм.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлд хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл Компанийн 2021 оны 12 дугаар сарын 31-нээрх жилийн тайланд багтсан мэдээллээс бүрдэх ба харин тусдаа санхүүгийн тайлан болон манай аудиторын тайланг багтаахгүй. Жилийн тайлан нь энэхүү аудиторын тайлан гарсан өдрөөс хойш бидэнд нээлттэй болно.

Тусдаа санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй бөгөөд бид аливаа хэлбэрээр баталгаажуулалтын дүгнэлт илэрхийлэхгүй.

Тусдаа санхүүгийн тайланд бидний хийсэн аудиттай холбоотой бидний үүрэг хариуцлага бол дээр тодорхойлсон бусад мэдээлэл бидэнд нээлттэй болсон үед уншиж танилцах, ингэхдээ уг бусад мэдээлэл нь тусдаа санхүүгийн тайлан эсвэл аудитаар бидний олж авсан мэдлэгтэй материаллаг хэмжээгээр харшилж байгаа эсвэл өөрөөр материаллаг байдлаар буруу илэрхийлэгдсэн эсэхийг авч үзэх юм.

Удирдлага болон Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн тусдаа Санхүүгийн тайланд хүлээх үүрэг хариуцлага

Компанийн удирдлага эдгээр тусдаа санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэгтэй. Удирдлагын тодорхойлох энэхүү дотоод хяналт нь тусдаа санхүүгийн тайланг аливаа алдаа эсвэл залилангийн улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай байдаг.

Удирдлага нь тусдаа санхүүгийн тайланг бэлтгэхдээ Компанийн үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

Санхүүгийн тайлагналын аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс тусдаа санхүүгийн тайланг нь бүхэлдээ анги эсэх талаарх үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Үл үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар оршин байгаа материаллаг алдаа зөрчлийг илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй.

Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ тусдаа санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

Аудитор нь залилан зэрэг хууль бус асуудлуудыг илрүүлэх чадавхийг ямар цар хүрээнд авч үзсэн талаарх тайлбар

АОУС-ын дагуух аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шийдэл ашиглаж аудитын ажлын явцад мэргэжлийн үл итгэх үзлийг хандлагыг баримтлан ажилладаг. Үүнд:

- Залилан эсвэл алдааны улмаас тусдаа санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын баримт нотолгоог олж авдаг. Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг, учир нь залиланд хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах явдлууд багтсан байж болно.
- Компанийн дотоод хяналтын үр ашигтай байдалд санал дүгнэлт өгөх зорилгоор биш харин тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулах зорилгоор аудитын ажилтай холбоотой дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогын тохиромжтой байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцоолол болон холбогдох тодруулгын үл үндэслэлтэй, байдлыг үнэлдэг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн компанийн тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг тодорхойлдог. Хэрэв материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторовн тайландаа тусдаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл ийм тодруулга хийх нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторовн тайлан гарах өдөр хүртэлх олж авсан аудитын баримт нотолгоондоо үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал Компани тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.
- Тодруулгыг багтаагаад тусдаа санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлж тусдаа санхүүгийн тайланд үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц хэмжээнд гол гол ажил гүйлгээ, үйл явдлыг илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог.

Бид аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа болон аудитын явцад олж илрүүлсэн дотоод хяналтын мэдэгдэхүйц доголдлыг багтаагаад нөлөө бүхий аудитын илрүүлэлтүүд, бусад томоохон асуудлуудаар засаглах эрх мэдэл бүхий удирдлагатай харилцдаг.

Бид хараат бус байдлын талаар холбогдох ёс зүйн шаардлагуудад нийцсэн гэдгээ засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдэд мэдэгддэг ба мөн бид тэдгээр хүмүүстэй бүх харилцаа холбоо болон шаардлагатай гэж үзвэл холбогдох хамгаалалт зэрэг бидний хараат бус байдлын хүрээнд бодолцож үзвэл зохих асуудлуудаар харилцдаг.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй харилцсан асуудлуудаас тайлант үеийн тусдаа санхүүгийн тайлангийн аудитад чухал асуудлуудыг тодорхойлж тэдгээр асуудлаа аудитын гол асуудлууд гэж үздэг. Хууль, дүрэм журмаар аливаа асуудлыг олон нийтэд мэдээллэхийг хориглосон эсвэл тун ховор тохиолдолд аудиторовн тайландаа аливаа асуудлаар харилцах нь тухайн харилцаанаас хүртэх олон нийтийн үр өгөөжөөс илүү сөрөг үр дагавартай учраас аудиторовн тайландаа харилцахгүй байх нь зүйтэй гэж үзсэнээс бусад тохиолдолд тэдгээр асуудлыг аудиторовн тайландаа тодорхойлдог.

Бусад хууль тогтоомж, зохицуулалтын шаардлагын талаар

Монгол улсын Компанийн тухай хуулийн 92, 94-р зүйлд заасны дагуу сонирхлын зөрчилтэй этгээдтэй хийсэн ажил гүйлгээ, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн Зохицуулах Хороо болон Монголын

Хөрөнгийн Биржээс тогтоосон бусад мэдээлэл, Компанийн дүрэмд заасан бусад мэдээллийг тайлагнах үүрэгтэй бөгөөд эдгээр зүйлстэй холбоотой ямар нэгэн зөрчил илрээгүй болно.

Аудитын тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг Компанийн тухай хуулийн 94-р зүйлд заасны дагуу зөвхөн компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулсан ба бусад өөр этгээдэд зориулаагүй болно. Бид энэхүү тайлангийн хүрээнд бусад аливаа нэгэн гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй.

Энэхүү Хараат бус аудиторын тайланг гаргахад оролцсон гэрээт ажлын Партнер нь Н.Эрдэнэцог болно.



Б.ОСОРГАРОВ
УДИРДАХ ПАРТНЕР



Н.ЭРДЭНЭЦОГ
ГЭРЭЭТ АЖЛЫН ПАРТНЕР

2022 оны 3 дугаар сарын 31
Улаанбаатар хот

Тусдаа санхүүгийн байдлын тайлан


Мянган төгрөгөөр	Тодруулга	2021 оны 12 сарын 31- ний үлдэгдэл	2020 оны 12 сарын 31- ний үлдэгдэл
Хөрөнгө			
Эргэлтийн хөрөнгө			
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	7	330,722	100,958
Дансны болон бусад авлага	8	23,076,380	1,685,343
Бусад санхүүгийн хөрөнгө	9	10,369,946	18,737
Бараа материал	10	107,959	2,112
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	11	3,708,456	1,243,564
Эргэлтийн хөрөнгийн дүн		37,593,463	3,050,714
Эргэлтийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө	12	645,221	466,025
Биет бус хөрөнгө	13	59,160,237	8,941,367
Ашиглах эрхтэй хөрөнгө	14.1	2,349,551	440,433
Урт хугацаат хөрөнгө оруулалт	15	231,730,778	67,481,313
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		293,885,787	77,329,138
Нийт хөрөнгө		331,479,250	80,379,852
Өр төлбөр ба эздийн өмч			
Өр төлбөр			
Богино хугацаат өр төлбөр			
Дансны болон бусад өглөг	17	28,703,917	4,552,360
Богино хугацаат зээл	18.1	6,182,791	1,147,287
Богино хугацаат хаалттай бондын өр төлбөр	18.2	3,685,489	11,958,106
Богино хугацаат санхүүгийн түрээсийн өглөг	14.2	979,547	349,718
Богино хугацаат өр төлбөрийн дүн		39,551,744	18,007,471

Тусдаа санхүүгийн байдлын тайлан (үргэлжлэл)

Мянган төгрөгөөр	Тодруулга	2021 оны 12 сарын 31- ний үлдэгдэл	2020 оны 12 сарын 31- ний үлдэгдэл
Урт хугацаат өр төлбөр			
Хойшлогдсон татварын өр	16	24,188,557	3,405,208
Урт хугацаат санхүүгийн түрээсийн өглөг	14.2	1,473,974	379,093
Урт хугацаат зээл	18.1	6,633,373	408,752
Урт хугацаат хаалттай бондын өр төлбөр	18.2	1,583,000	2,347,232
Урт хугацаат өр төлбөрийн дүн		33,878,904	6,540,285
Өр төлбөрийн нийт дүн		73,430,648	24,547,756
Эздийн өмч			
Өмч-хувьцаат	19.1	28,614,263	28,590,335
Халаасны хувьцаа		-	(1,414,706)
Нэмж төлөгдсөн капитал	19.2	2,927,696	-
Дахин үнэлгээний нөөц	19.4	214,347,421	27,284,096
Эздийн өмчийн бусад хэсэг		13,799	13,799
Хуримтлагдсан ашиг	19.3	12,145,423	1,358,572
Эздийн өмчийн дүн		258,048,602	55,832,096
Өр төлбөр ба эздийн өмчийн дүн		331,479,250	80,379,852

Уг тусдаа санхүүгийн байдлын тайланг 2022 оны 3 дугаар сарын 31-ний өдөр батлав:


Ч.Ганхуяг
Гүйцэтгэх захирал


Б.Золбоо
Санхүү эрхэлсэн захирал

Хуудас 16-50-д харуулсан тодруулгууд нь энэхүү тусдаа санхүүгийн байдлын тайлангийн салшгүй нэг хэсэг болно.

Тусдаа орлогын дэлгэрэнгүй тайлан

Мянган төгрөгөөр	Тодруулга	2021 он	2020 он
Хөрөнгө оруулалтын менежментийн үйлчилгээний орлого	20.1	2,030,180	688,461
Ашиг алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлт ба данснаас хассаны олз	20.2	3,356,706	303,915
Ногдол ашгийн орлого	20.3	1,004,162	1,311,736
Хөрөнгө оруулалтын багцын хүүгийн орлого	20.4	1,316,383	29,984
Нийт хөрөнгө оруулалтын орлого		7,707,431	2,334,096
Хөрөнгө оруулалтын бус бусад орлого	21	784,268	916,740
Борлуулалт, маркетингийн зардал	22	(1,095,852)	(271,381)
Ерөнхий ба удирдлагын зардал	23	(16,266,063)	(3,183,791)
Санхүүгийн зардал	24	(3,346,137)	(2,876,353)
Бусад зардал	25	(2,349,625)	(785,887)
Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	26	(361)	(170,140)
Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз		(26,955)	-
Виртуал хөрөнгийг данснаас хассаны олз		14,351,507	-
Татвар төлөхийн өмнөх алдагдал		(241,787)	(4,036,716)
Орлогын татварын өгөөж	27	27,437	2,041
Тайлант үеийн цэвэр алдагдал		(214,350)	(4,034,675)
Бусад дэлгэрэнгүй орлого			
Бусад дэлгэрэнгүй орлогоор дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө болон виртуал хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлт		187,063,325	3,178,618
Бусад дэлгэрэнгүй орлогоор дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө болон виртуал хөрөнгийг данснаас хассаны олз		11,805,694	1,056,403
Бусад дэлгэрэнгүй орлогын дүн		198,869,019	4,235,021
Нийт дэлгэрэнгүй ашиг		198,654,669	200,346
Нэгж хувьцаанд ногдох суурь алдагдал		(0.01)	(0.15)

Хуудас 16-50-д харуулсан тодруулгууд нь энэхүү тусдаа орлогын дэлгэрэнгүй тайлангийн салшгүй нэг хэсэг болно.

Тусдаа өмчийн өөрчлөлтийн тайлан

Мянган төгрөгөөр	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Дахин үнэлгээний нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2020 оны 1 сарын 1-ний үлдэгдэл	28,590,335	(1,414,706)	-	24,105,478	13,799	5,287,424	56,582,330
Тайлант үеийн цэвэр алдагдал	-	-	-	-	-	(4,034,675)	(4,034,675)
Хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлт	-	-	-	4,235,021	-	-	4,235,021
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-	(950,580)	(950,580)
Дахин үнэлгээний нөөцөөс хэрэгжсэн дүн	-	-	-	(1,056,403)	-	1,056,403	-
2020 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	28,590,335	(1,414,706)	-	27,284,096	13,799	1,358,572	55,832,096
Тайлант үеийн цэвэр алдагдал	-	-	-	-	-	(214,350)	(214,350)
Хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлт	-	-	-	198,869,019	-	-	198,869,019
Өмчид гарсан өөрчлөлт	23,928	1,414,706	2,927,696	-	-	(23,928)	4,342,402
Дахин үнэлгээний нөөцөөс хэрэгжсэн дүн	-	-	-	(11,805,694)	-	11,025,129	(780,565)
2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	28,614,263	-	2,927,696	214,347,421	13,799	12,145,423	258,048,602

Хуудас 16-50-д харуулсан тодруулгууд нь энэхүү тусдаа өмчийн өөрчлөлтийн тайлангийн салшгүй нэг хэсэг болно.

Тусдаа мөнгөн гүйлгээний тайлан

Мянган төгрөгөөр	2021 он	2020 он
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн	2,782,715	417,427
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	2,782,715	-
Бусад мөнгөн орлого	-	417,427
Мөнгөн зарлагын дүн	8,302,909	4,928,032
Ажиллагчдад төлсөн	1,487,785	435,619
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	271,633	73,927
Бараа материал худалдан авахад төлсөн	117,682	10,421
Ашиглалтын зардалд төлсөн	52,037	622,131
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	135,533	15,773
Хүүний төлбөрт төлсөн	2,730,145	1,825,104
Татварын байгууллагад төлсөн	1,001,667	119,558
Даатгалын төлбөрт төлсөн	26,755	10,903
Бусад мөнгөн зарлага	2,479,672	1,814,596
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(5,520,194)	(4,510,605)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн	51,176,390	3,272,094
Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	10,800,405	-
Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	20,850,000	-
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	17,665,239	3,197,168
Хүлээн авсан хүүний орлого	957,000	900
Хүлээн авсан ногдол ашиг	903,746	74,026

Тусдаа мөнгөн гүйлгээний тайлан (үргэлжлэл)

Мянган төгрөгөөр	2021 он	2020 он
Мөнгөн зарлагын дүн	49,492,446	1,407,956
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	601,044	3,823
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	100,000	-
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	13,587,474	1,143,667
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	35,203,928	260,466
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,683,944	1,864,138
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн	20,768,079	9,922,914
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	20,768,079	3,749,000
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	6,173,914
Мөнгөн зарлагын дүн	16,702,065	7,218,725
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	16,415,124	2,918,723
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	137,863	224,543
Хувьцаа буцаан худалдаж авхад төлсөн	-	3,768,800
Төлсөн ногдол ашиг	149,078	306,659
Бусад мөнгөн зарлага	-	-
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	4,066,014	2,704,189
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	229,764	57,722
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	100,958	43,236
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	330,722	100,958

Хуудас 16-50-д харуулсан тодруулгууд нь энэхүү тусдаа мөнгөн гүйлгээний тайлангийн салшгүй нэг хэсэг болно.

